

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Дотоодын банк хоорондын гадаад валютын захад Монголбанкнаас оролцох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах замаар гадаад валютын дотоод захын үр ашгийг нэмэгдүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг зах зээлийн зарчмаар тодорхойлох зорилгоор Монголбанкнаас зохион байгуулах гадаад валютын дуудлага худалдаа (цаашид дуудлага худалдаа гэх)-нд баримтлах зарчим, талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Монголбанкны дуудлага худалдаанд зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банк оролцоно.
- 1.3. Аж ахуйн нэгж байгууллага, иргэд нь өөрийн харилцагч банкаар дамжуулан дуудлага худалдаанд оролцох боломжтой.
- 1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.4.1. “Ялгаатай ханшаар хийх арилжаа” гэж амжилттай биелсэн банкуудын саналыг тухайн саналын ханшаар биелүүлэх арилжааг;
 - 1.4.2. “Нэг ханшаар хийх арилжаа” гэж амжилттай биелсэн банкуудын бүх саналыг хаалтын нэг ханшаар биелүүлэх арилжааг;
 - 1.4.3. “Хаалтын ханш” гэж тухайн дуудлага худалдаанд биелсэн худалдах саналын хамгийн их, худалдан авах саналын хамгийн бага ханшийг;
 - 1.4.4. “Гадаад валютын цахим арилжааны систем” гэж Монголбанк болон банкуудын хооронд хийж буй дуудлага худалдааны арилжааг гүйцэтгэх цахим системийг.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 дугаар тушаалаар нэмсэн./](#)

Хоёр. ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1. Монголбанк дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагийн 09:30 цагт зохион байгуулна. Хэрэв уг өдөр нь нийтээр амрах баярын өдөр тохиовол өмнөх ажлын өдөр дуудлага худалдааг зохион байгуулна.
- 2.2. Дуудлага худалдаа нь бэлэн бус ам.доллар, юанийн гүйлгээгээр хязгаарлагдана.
- 2.3. Нэг удаагийн дуудлага худалдаанд банк нь гадаад валютыг худалдах эсвэл худалдан авах 3 (гурав) хүртэлх саналаар оролцоно.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А-136 дугаар тушаалаар өөрчилсөн./](#)

2.3¹ Дуудлага худалдаа нь “ялгаатай ханшаар хийх арилжаа”, “нэг ханшаар хийх арилжаа”-ны хэлбэртэй байна;

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 дугаар тушаалаар нэмсэн./](#)

2.4. Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валют худалдан авах, худалдах саналыг дамжуулж буй банк нь энэ журмын 2.3-т зааснаас гадна зөвхөн Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валют худалдах эвсэл худалдан авах 5 (тав) хүртэлх саналаар нэг удаагийн дуудлага худалдаанд оролцоно.

Гурав. БАНКИНД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. Зөвхөн дараах шаардлагыг хангасан саналыг дуудлага худалдаанд оролцуулахаар баталгаажуулна:

3.1.1. Гадаад валютын зохистой харьцааны тайланг дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнөх байдлаар гарган Монголбанкинд дуудлага худалдаа болох өдөр 10:00 цагаас өмнө хүргүүлсэн байх;

3.1.2. Худалдах, худалдан авах валютын хэмжээ болон ханшийн саналаа арилжаа явагдах өдрийн 9:30-10:00 цагийн хооронд “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр дамжуулан Монголбанкны Зах зээлийн газар (цаашид ЗЗГ гэх)-ын Дотоод зах зээлийн хэлтэс (цаашид ДЗЗХ гэх)-т ирүүлсэн байх;

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./](#)

3.1.3. “Гадаад валютын цахим арилжааны систем”-д энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан мэдээллүүдийг бүрэн оруулсан байх;

3.1.4. Банк нь тухайн дуудлага худалдаагаар худалдах, худалдан авах валютын төлбөрийг гүйцэтгэх хангалттай хэмжээний эх үүсвэрийг Монголбанкн дахь харилцах дансандаа дуудлага худалдаа эхлэхээс өмнө төвлөрүүлсэн байх;

3.1.5. Гадаад валютыг худалдах/худалдан авах нэгж саналын дүн нь Монголбанкны тогтоосон дээд, доод хэмжээнээс илүү буюу бага биш байна.

3.2. Банк нь энэ журмын 2.4-т зааснаар банк бус санхүүгийн байгууллагын валют худалдах, худалдан авах саналыг дамжуулах эрх нээлгэхдээ Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, банк бус санхүүгийн байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, Монголбанкинд хувийг ирүүлсэн байна.

Дөрөв. ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ САНАЛЫГ ЦУЦЛАХ

4.1. Энэ журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй банкны тухайн валютын бүх саналыг цуцална.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./](#)

4.2. Энэ журмын 2.4-т зааснаас бусад зориулалтаар ирүүлсэн банкны аливаа саналыг цуцална.

- 4.3. Тухайн банкны ирүүлсэн саналын ханш нь зах зээлийн ханшаас хэт зөрүүтэй үед Монголбанк саналыг цуцалж болно.
- 4.4. Монголбанк цуцлагдсан саналын талаарх мэдээллийг “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр эсвэл цахим шуудангаар дамжуулан тухайн өдрийн 11:30 цагийн дотор банкинд мэдэгдэнэ.

Тав. ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1. Дуудлага худалдааны санал авах үйл ажиллагаа тухайн өдрийн 9:30 цагт эхэлж 10:00 цагт дуусна.
- 5.2. Дуудлага худалдаагаар биелсэн худалдан авах саналыг дараах байдлаар тодорхойлно:
- 5.2.1. Баталгаажсан бүх саналыг хамгийн өндөр худалдан авах ханшаас эхлэн хамгийн бага ханш хүртэл эрэмбэлнэ.
- 5.2.2. Дуудлага худалдаагаар худалдах гадаад валютын хэмжээг дуусгавар болох хүртэл баталгаажсан саналыг хамгийн өндөр худалдан авах ханшаас эхлэн биелүүлнэ. Хэрэв тухайн өдөр дуудлага худалдаагаар Монголбанкны худалдах гадаад валютын дүнгээс биелэх саналын нийлбэр дүн нь хэтэрсэн тохиолдолд хамгийн бага биелэгдэх ханш дээр ирсэн санал бүрийг нийт уг ханш дээр ирүүлсэн саналд харьцуулж тооцсон харьцаагаар энэ ханш дээр Монголбанкны худалдах гадаад валютын хэмжээнд үржүүлэн гадаад валютыг хуваарилна.
- 5.3. Дуудлага худалдаанд биелэгдсэн худалдах саналыг дараах байдлаар тодорхойлно:
- 5.3.1. Баталгаажсан бүх саналыг хамгийн бага худалдах ханшаас эхлэн хамгийн өндөр ханш хүртэл эрэмбэлнэ.
- 5.3.2. Дуудлага худалдаагаар худалдан авах гадаад валютын хэмжээг дуусгавар болох хүртэл баталгаажсан саналыг хамгийн бага худалдах ханшаас эхлэн биелүүлнэ. Хэрэв тухайн өдөр дуудлага худалдаагаар худалдах гадаад валютын дүнгээс биелэгдэх саналын нийлбэр дүн нь хэтэрсэн тохиолдолд хамгийн өндөр биелэгдэх ханш дээр ирсэн санал бүрийг нийт уг ханш дээр ирүүлсэн саналд харьцуулж тооцсон харьцаагаар энэ ханш дээр Монголбанкны худалдан авах гадаад валютын хэмжээнд үржүүлэн саналыг биелүүлнэ.
- 5.4. Дуудлага худалдааны үр дүнгийн талаарх мэдээллийг 11:30 цагаас өмнө энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр банкуудад хүргэх бөгөөд Монголбанкны албан ёсны цахим хуудаст тухайн өдөрт багтаан нийтэлнэ.
- 5.5. Давагдашгүй хүчин зүйл болон цахим арилжааны сүлжээнд эвдрэл гарсны улмаас дуудлага худалдааны санал авах үйл ажиллагаа тухайн өдрийн 9:30 цагт эхлэх боломжгүй бол дараах ажиллагааг үйлдэнэ:
- 5.5.1. Монголбанк арилжаа хийх хугацааг сунгаж болно. Ингэхдээ банкуудад “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр эсвэл утсаар мэдэгдэнэ.
- 5.5.2. Цахим арилжааны сүлжээнд гарсан эвдрэлийг засах боломжгүй бол энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу банкуудаас гадаад валютын худалдах, худалдан авах саналыг бичгээр авна. Монголбанкны эдийн засагч нь банкны саналын битүүмж,

лацыг шалгаж, банкны ажилтантай энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу баримт үйлдэнэ. Монголбанк битүүмжлээгүй саналыг хүлээн авахгүй.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./](#)

5.6. “Гадаад валютын цахим арилжааны систем”-д банк нууц дугаар, нууц үгийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд цахим хэрэглээний эрхийг түр хаана. Энэ тохиолдолд банк нь арилжаа явагдах хугацаа болохоос өмнө ЗЗГ-ын ДЗЗХ-т утсаар мэдэгдэж хэрэглэгчийн эрхээ сэргээлгэнэ.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./](#)

5.7. Банк нь шинээр хэрэглэгчийн нэр, нууц үг авах тохиолдолд хүсэлтээ албан бичгээр ЗЗГ-ын ДЗЗХ-т ирүүлнэ. Албан бичигт хэрэглэгчийн нэр, нууц дугаар шинээр авах шалтгаан, эрх бүхий ажилтны нэрийг тусгасан байна.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./](#)

Зургаа. МОНГОЛБАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Дуудлага худалдааг ЗЗГ-ын ДЗЗХ зохион байгуулна.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./](#)

6.2. Монголбанк тухайн дуудлага худалдаагаар худалдах, худалдан авах валютын хэмжээ, арилжааны хэлбэрийг тогтооно.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./](#)

6.3. Монголбанк дуудлага худалдаагаар худалдах, худалдан авах гадаад валютын нэгж саналын дүнг тогтооно. Энэ дүн өөрчлөгдөх тухай бүр Монголбанк дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнө банкуудад цахим шуудангаар энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу мэдэгдэнэ.

6.3¹ Монголбанк дуудлага худалдааны арилжааны хэлбэрийг урьдчилан зарлахгүй байж болно.”

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 дугаар тушаалаар нэмсэн./](#)

6.4. Дуудлага худалдаанд банкуудаас ирүүлсэн саналын ханш нь зах зээлийн ханшаас хэт зөрүүтэй эсвэл шударга бус, хуйвалдсан гэж үзвэл Монголбанк тухайн санал, дуудлага худалдааг цуцлах эрхтэй.

6.5. Монголбанк нь банкуудын дуудлага худалдаатай холбоотой мэдээ, мэдээллийг нууцална.

6.6. Монголбанк шаардлагатай гэж үзвэл дуудлага худалдааг цуцлах, энэхүү журмын 2.1-т зааснаас бусад өдөр зохион байгуулах, тухайн өдрийн дуудлага худалдааг зохион байгуулахаас татгалзах эрхтэй. Ингэхдээ банкуудад дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнө цахим шуудангаар мэдэгдэнэ.

- 6.7. Монголбанк дуудлага худалдааны төлбөр тооцоог дуудлага худалдаа болсон өдрийн 13:00 цагаас өмнө хийж гүйцэтгэнэ.
- 6.8. Энэ журмын 7.5-д заасан заалтыг зөрчсөнөөс үүдэн гарах аливаа хохирлыг Монголбанк хариуцахгүй болно.

Долоо. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Банк нь дуудлага худалдаатай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг үнэн зөв гаргаж, дуудлага худалдаанд шударгаар оролцоно.
- 7.2. Банк нь худалдах, худалдан авах саналаа “Гадаад валютын цахим арилжааны систем”-д нэгэнт баталгаажуулсан бол уг саналаас татгалзах, түүнийг буцаах, өөрчлөх эрхгүй.
- 7.3. Энэ журмын 5.5.2-т заасны дагуу дуудлага худалдаанд бичгээр ирүүлсэн санал нь банкны итгэмжлэгдсэн албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.
- 7.4. Банкны гарын үсгийн баталгаа, цахим шуудангийн хаяг өөрчлөгдвөл дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнө Монголбанкинд бичгээр мэдэгдэнэ.
- 7.5. Банк нь “Гадаад валютын цахим арилжааны систем”-д нэвтрэх нууц дугаарыг нууцална.

Найм. ХАРИУЦЛАГА

- 8.1. Энэ журмын аливаа заалтыг зөрчсөн банкинд Монголбанк дараах хариуцлагыг тооцно:
- 8.1.1. Энэ журмын аливаа заалтыг эхний удаа зөрчсөн тохиолдолд Монголбанкны улсын байцаагч банкинд мэдэгдэх хуудас хүргүүлж, “Банкны тухай хууль”-ийн 68 дугаар зүйлийн дагуу мөнгөн торгууль ногдуулна. Ингэхдээ тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас үл маргах журмаар хасалт хийнэ.
- 8.1.2. Банк энэ журмын аливаа заалтыг давтан зөрчсөн тохиолдолд “Банкны тухай хууль”-ийн 68 дугаар зүйлийн дагуу мөнгөн торгууль ногдуулахаас гадна дуудлага худалдаанд оролцох 8 (найман) удаагийн эрхийг хасна.
- 8.1.3. Банк нь удаа дараа энэ журмын заалтыг зөрчвөл банкны дуудлага худалдаанд оролцох эрхийг бүрмөсөн хасна.

**ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНД
ОРОЛЦОХ САНАЛЫН МАЯГТ**

.... оны сарын өдөр

Арилжааны банкны нэр:

Нийт худалдан авахаар санал болгож буй гадаад валютын дүн:

Нийт худалдахаар санал болгож буй гадаад валютын дүн:

1. Гадаад валютыг худалдан авах санал

Саналын дугаар	Худалдан авах ам.доллар/юанийн хэмжээ	Худалдан авах ханш
1		
2		
3		
4		
5		
Дүн		

2. Гадаад валютыг худалдах санал

Саналын дугаар	Худалдах ам.доллар/юанийн хэмжээ	Худалдах ханш
1		
2		
3		
4		
5		
Дүн		

НЭГДҮГЭЭР ГАРЫН ҮСЭГ:

ХОЁРДУГААР ГАРЫН ҮСЭГ:

ТАМГА:

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ:

“Гадаад валютын дуудлага худалдааны журам”-ын
2 дугаар хавсралт

МЭДЭГДЭЛ

Гадаад валютын 20... оны ... сарын ... өдрийн дуудлага худалдаа

1. Монголбанкны гадаад валют худалдан авах хаалтын ханш: төгрөг
2. Монголбанкны гадаад валют худалдах хаалтын ханш: төгрөг

МОНГОЛБАНК

САНАЛ ХҮЛЭЭЛЦСЭН БАРИМТ

... оны ... сарын ... өдөр

Дугаар	Банкны нэр	Хүлээлгэн өгсөн ажилтны нэр, тушаал овог албан	Хүлээлгэн өгсөн ажилтны гарын үсэг	Хүлээн авсан Монголбанкны ажилтны гарын үсэг	Хүлээн авсан цаг
1					
2					
3					
4					
5					
6					
.....					

МЭДЭГДЭЛ

. . . оны . . . сарын . . . өдөр

“Гадаад валютын дуудлага худалдааны журам”-ын 6.3 дахь заалтыг үндэслэн дуудлага худалдаагаар худалдан авах/худалдах нэг саналын дүн оны сарын өдрөөс эхлэн ам.доллараас илүүгүй, ам.доллараас багагүй болсныг үүгээр мэдэгдье.

МОНГОЛБАНК